



СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

МОНГОЛЫН ХОЛИМОГ ТУЛААНЫ ХОЛБОО (МХТХ)

Эрхэм зорилго

Холимог тулааны спортыг Монгол улсад таниулан сурталчилж, хөгжүүлэх. Тамирчдын хөгжлийг эмх цэгцтэй, шат дараалсан урт хугацааны хөтөлбөр, сайн засаглалаар дамжуулан дэмжих. Сонирхогчийн холимог тулаан дахь олон улсын стандартыг дагаж мөрдөн олимпын наадмын хөтөлбөрт холимог тулааныг нэмэхэд хувь нэмрээ оруулах.

Алсын хараа

Монгол орныг дэлхийн холимог тулааны спортын тэргүүлэх гүрнүүдийн нэг болгох. Авьяас чадвартай тамирчдыг хөгжүүлэн дэмжиж, шударга цэвэр өрсөлдөөнийг эрхэмлэх. Холимог тулааны спортыг олимпын наадмын хөтөлбөрт нэмэхэд хувь нэмрээ оруулах.

Үүрэг болон Хариуцлага

Гол зорилтууд:

- МХТХ нь холимог тулааны спортыг Монгол улсад таниулж, хөгжүүлэх үүрэг хүлээсэн Олон Улсын Холимог Тулааны Холбооны (ОУХТХ) гишүүн байгууллага юм.
- МХТХ нь ОУХТХ-ны Ёс зүйн дүрэм болон Дэлхийн Допингийн Эсрэг Агентлаг (ДДЭА)-ийн цэвэр, шударга спортын дүрмийг дагаж мөрдөнө.
- МХТХ нь Олон Улсын Олимпын Хороогоор (ОУОХ) холимог тулааныг хүлээн зөвшөөрүүлж, олимпын наадмын хөтөлбөрт оруулах зорилгын төлөө идэвх чармайлт гарган ажиллах болно.

Сайн засаглал

Гол зорилгууд:

- **Сайн засаглалыг хөгжүүлэх:** МХТХ нь засаглалын хүчирхэг баазыг бий болгож, бүх насны тамирчид, дасгалжуулагчид, албаны хүмүүс болон бусад талуудын хөгжлийг дэмжин ажиллана.

- **Гишүүнчлэлээ нэмэгдүүлэх:** МХТХ нь ОУХТХ-ны дүрэм журмыг даган мөрдөж, холимог тулааны спортын хөгжилд хувь нэмрээ оруулах хүсэлтэй шинэ гишүүдэд үргэлж нээлттэй байх болно.

2024–2026 оны стратегийн төлөвлөгөө

1. Холимог тулаан сонирхогчдыг дижитал платформоор дамжуулан татах

Холимог тулаан сонирхогчдын анхаарлыг татаж, цар хүрээгээ тэлэхэд технологийн ололтуудыг түүчээлэн ашиглах.

- **Үнэлгээний болон Гишүүнчлэлийн платформ бүтээх:** Тамирчдын үнэлгээ, гишүүнчлэл болон тэмцээнд оролцогчдын тоог хянахад онлайн системийг ашиглах.
- **Дижитал платформуудыг ашиглан хөгжөөн дэмжигчдийг татах:** ТВ-н нэвтрүүлэг, шууд дамжуулалт, социал медиа постуудаар дамжуулан онлайн ертөнцөд өөрсдийн байр сууриа эзлэх.

2. Тэмцээний календарь

Тамирчдын оролцоог нэмэгдүүлэхийн тулд тэмцээний давтамж болон чанарыг сайжруулах.

- **Дотоодын тэмцээнүүд:** Тамирчдад туршлага хуримтлуулж, өөрсдийгөө сорьж, чадвараа батлан харуулах боломж олгох үүднээс төрөл бүрийн насны болон түвшний тэмцээнүүдийг тогтмол зохион байгуулах.
- **Тив болон Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнүүд:** Тив болон дэлхийн түвшний тэмцээнүүдэд оролцох боломжийг олгох. Олон улсад өрсөлдөхөд шаардлагатай бэлтгэлийн бааз, тоног төхөөрөмж, зардалд дэмжлэг үзүүлэх.

3. Орлогын эх үүсвэрүүд

МХТХ-г санхүүгийн хувьд тогтвортой байлгах үүднээс орлогын эх үүсвэрүүдийг төрөлжүүлэх.

- **Гишүүнчлэлийн төлбөр:** МХТХ-ны санхүүгийн тогтвортой байдлыг хангах үүднээс гишүүнчлэлийн төлбөрийг авдаг болох. Гишүүнчлэлийн төлбөрийг төлөхөд хялбар дөхөм байлгах.
- **Ивээн тэтгэгчид:** МХТХ-ны санхүүгийн урт хугацааны тогтвортой байдлыг хангахын тулд тэмцээн, сургалтын хөтөлбөр, бүх насны шигшээ багуудыг тодорхой ивээн тэтгэгчтэй болгох.
- **Тэмцээний орлого:** Мэргэжлийн холимог тулааны тэмцээн зохион байгуулж ивээн тэтгэгчдийг татах. Авьяаслаг тамирчдад өөрсдийгөө батлан харуулах боломж олгох.
- **Боловсролын хөтөлбөрүүд:** Тамирчид болон дасгалжуулагчдад зориулсан боловсролын баримт материалыг онлайн хэлбэрээр хөгжүүлж орлогын нэмэлт эх үүсвэрийг бий болгох.

4. Сайн засаглал ба Хороодын хөгжил

Үйл ажиллагааны гол чиглэлүүдийг хянах ажлын хороодыг зохион байгуулах. Хороодоор дамжуулан үр дүнтэй шийдвэр болон үйл ажиллагааны эмх цэгцтэй байдлыг хангах.

- **Хороод:**

- **Техникийн хороод:** Холимог тулаан дахь цэвэр, шударга байдлыг хангахын тулд октагоны шүүгч, хажуугийн шүүгч, катменүүдийн сургалт, хөгжил, гэрчилгээжүүлэлт зэргийг хариуцна.
- **Допингийн эсрэг хороо:** ДДЭА-ийн стандартын дагуу допингийн эсрэг бодлогыг хэрэгжүүлж, сургалт явуулах, спорт дахь цэвэр, шударга байдлыг хадгалах.
- **Санхүү, Ивээн тэтгэлэг болон Маркетингийн хороо:** МХТХ-ны санхүүгийн асуудлуудыг удирдаж, ивээн тэтгэгчдийг олж гэрээ байгуулах. Монголд холимог тулааны спортыг эерэгээр таниулан сурталчлахад чиглэсэн төлөвлөгөөг боловсруулах.
- **Дасгалжуулалт болон Спортын хөгжлийн хороо:** Тамирчдын амжилт, дасгалжуулалтын чанарыг тогтмол сайжруулах үүднээс дасгалжуулагчдад зориулсан сургалт, семинар, хөтөлбөрүүдийн хөгжлийг хариуцна.
- **Эрүүл мэндийн хороо:** Тамирчдын эрүүл, аюулгүй байдлыг хангах үүднээс бүх тамирчид тэмцээнд оролцохын өмнө зохих эрүүл мэндийн үзлэгт орж эмчийн бичиг авсан эсэхийг хянана.

5. Тамирчдын аюулгүй байдал болон Эрүүл мэнд

Олон улсад жишиг болсон протоколуудыг ашиглан тамирчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах. Таниулга хийх.

- **Тэмцээний өмнөх эрүүл мэндийн үзлэг:** Тамирчин бүр тэмцээний өмнө эрүүл мэндийн үзлэгт орж, цусны шинжилгээ өгөн Гепатит Б, С болон ХДХВ-н халдваргүй гэдгээ баталгаажуулсан байх ёстой.
- **Тэмцээний дараах бэртлийн протокол:** Олон улсын стандартын дагуу тамирчдын эрүүл мэндийг хамгаалахын тулд нокаут (КО), техникийн нокаут (ТКО) эсвэл тархи, толгойн гэмтэл авсан тохиолдолд тамирчинд 45 хоногийн сэргэх хугацаа олгох. Тархи, толгойн хүнд гэмтэл авсан бол тамирчны тэмцээнд оролцох эрхийг түр хугацаанд түдгэлзүүлэх.

6. Допингийн эсрэг хөтөлбөр

Тамирчдын эрүүл мэнд, спорт дахь цэвэр, шударга байдлыг хангахын тулд допингийн эсрэг хатуу бодлого баримтлах.

- **ДДЭА-ийн дүрмийг хэрэгжүүлэх:** МХТХ нь ОУХТХ-ны допингийн эсэг бодлого болон ДДЭА-ийн шинжилгээ, судалгаа, боловсролын стандартыг дагаж мөрдөн, спорт дахь цэвэр, шударга байдлыг ханган ажиллана.

- **Допингийн эсрэг боловсрол:** Тамирчин, дасгалжуулагч болон албаны хүмүүс бүгд допингийн эсрэг боловсролын сургалтад хамрагдаж, цэвэр, шударга спортын ач холбогдлыг ойлгож ухамсарласан байх ёстой.
 - **Үндэсний допингийн эсрэг газартай хамтрах:** Үндэсний Допингийн Эсрэг Байгууллага (ҮДЭБ)-тай хамтран ажиллаж, дэлхийн стандартыг Монголд хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулах.
-

Гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд (KPIs)

- **Тэмцээнд оролцогчдын тоо:** Орон нутаг, үндэсний болон олон улсын түвшний тэмцээн, арга хэмжээнд оролцож байгаа тамирчин, дасгалжуулагчдын тоог өсгөн нэмэгдүүлэх.
 - **Гишүүдийн тоо:** МХТХ-ны гишүүдийн тоог үйл ажиллагаа, тэмцээн, арга хэмжээ, хөтөлбөрүүд болон дижитал сувгуудаар дамжуулан өсгөх.
 - **Ивээн тэтгэгчид болон Орлогын өсөлт:** Ивээн тэтгэгчидтэй байгуулсан гэрээ болон тэмцээн, гишүүнчлэлийн орлогын амжилтыг хянах.
 - **Цэвэр, шударга спорт:** Бүх тамирчид болон албаны хүмүүс допингийн эсрэг дүрэм журам, эрүүл мэндийн үзлэгийн протоколыг дагаж мөрдөж байгаа эсэхийг хянах.
-

Хэрэгжүүлэлт ба Цаг хугацаа

Жил 1 (2024):

- Гишүүнчлэлийн болон үнэлгээний платформуудыг үүсгэн байгуулах, удирдлагын ажлуудыг эмх цэгцэнд оруулах, тамирчид болон гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх.
- Үндэсний хэмжээний тэмцээн, арга хэмжээ, хөтөлбөрүүдийг зохион байгуулах. Холимог тулааны спортыг орон даяар түгээн таниулах аяныг өрнүүлэх. Бүх түвшинд авьяас чадвартай, тууштай, идэвхтэй тамирчдыг дэмжиж ажиллах.
- МХТХ-ны санхүүгийн тогтвортой моделийг бий болгож, хамтран ажиллагч болон ивээн тэтгэгч байгууллагуудтай бат бөх холбоо харилцаа тогтоож, гэрээ байгуулах.

Жил 2 (2025):

- Тэмцээний календарийг тив болон дэлхийн түвшний тэмцээнүүдээр өргөжүүлэх. Тамирчдад олон улсын тавцанд өрсөлдөж, өөрсдийгөө сорих боломжийг олгох.
- Допингийн эсрэг болон эрүүл мэндийн протоколтой холбоотой хөтөлбөрүүдийг тогтмол хэрэгжүүлж, тамирчдын аюулгүй байдал, эрүүл мэнд болон спорт дахь цэвэр, шударга байдлыг нэн тэргүүнд тавих.
- Холимог тулааныг олон нийтэд сурталчилж, түгээн дэлгэрүүлэхийн тулд ТВ болон социал медиагаар мэдээ, нэвтрүүлэг, шууд дамжуулалт болон пост тогтмол явуулах.

Жил 3 (2026):

- Холимог тулааныг ОУОХ-гоор хүлээн зөвшөөрүүлж, олимпын наадмын хөтөлбөрт оруулах зорилгын биелэлт хэр зэрэг урагштай байгааг хянаж, олон улсын холбоодтой энэ зорилгын төлөө нягт хамтран ажиллах.
- Засаглалын бүтэц болон үйл ажиллагааг бэхжүүлж сайжруулахын тулд дасгалжуулалтын гэрчилгээний хөтөлбөрийг тэлж, хороодын ажлын хамрах цар хүрээг нэмэгдүүлэх.
- Холбооны урт хугацааны тогтвортой байдлыг хангахын тулд санхүүгийн өсөлт, ивээн тэтгэгчдийн гэрээ болон арга хэмжээний үр дүнтэй байдлыг өсгөн нэмэгдүүлэх.

Дүгнэлт

МХТХ-ны стратегийн төлөвлөгөө нь Монгол орныг холимог тулааны спорт дахь дэлхийн тэргүүлэх гүрнүүдийн нэг болгох үндсэн зорилготой юм. Үүнийхээ төлөө бид өсвөр үеийн тамирчдын хөгжлийг дэмжиж, засаглалаа сайжруулж, санхүүгийн тогтвортой байдлыг хангахын төлөө хичээл зүтгэл гарган ажиллах болно. Энэхүү стратегийн төлөвлөгөө нь МХТХ-ны үйл ажиллагааг сайжруулж, холимог тулааны спортыг монголд хөгжүүлж дэлгэрүүлэхээс гадна олон улсын түвшинд холимог тулааны хөгжлийг хурдасгахад чухал үүрэг оролцоотой юм. Цаашлаад холимог тулааныг олон улсад хүлээн зөвшөөрүүлж, олимпын наадмын хөтөлбөрт багтаахад энэхүү стратеги төлөвлөгөө нь хувь нэмрээ оруулах болно.